

ТАНИЛЦУУЛГА

*Хамтарсан тушаалын төсөл
боловсруулсан тухай*

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь хэмжээг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална” гэж тус тус заасан.

Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758/А/197 дугаар хамтарсан тушаалаар даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна.

Дээрх тушаал нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчлэсэн найруулга)-ийг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт, зааврыг эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан.

Иймд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай хамтарсан тушаалын төсөл боловсрууллаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон даатгуулагчийн тоо 103.2 мянга байгаа нь манай улсын нийт хүн амын 3.1 хувийг эзэлж байна.

Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгосон 103.2 мянган даатгуулагчийн 46.5 хувь нь хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар буюу бүрэн, 53.5 хувь нь 70 хүртэл хувиар буюу хагас (хэсэгчилэн) алдсан байна.

Хөдөлмөрийн чадвар алдсан нийт хүний 59.6 хувь нь эрэгтэй, 40.4 хувь нь эмэгтэй байна.

2022 онд нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа алдсан 64.7 мянган тэтгэвэр авагчид 346.7 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн сангаас 38.5 мянган тэтгэвэр авагчид 114.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан голлох 5 шалтгаанд дотрын өвчин, сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, гэмтэл согогийн болон нүдний өвчнүүд орж байна.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/192 дугаар тушаалаар байгуулсан.

Энэхүү ажлын хэсгийн хурал хэлэлцүүлэг, хуралдааныг 5 удаа зохион байгуулж даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт, зааврын төслийг шинэчлэн боловсруулав.

Ердийн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох шинэчилсэн жагсаалтын заалтын ангилал, тоо

	№	Өвчний заалтын ангилал	Ерөнхий заалтын		Үе шатгүй	Нийт заалтын	Хугацаагүй заалтын	Нэмсэн заалт	Өөрчилсөн заалт	Хассан заалт
			Үе шаттай	Үе шатгүй						
Ердийн өвчин	1	Халдварт өвчин	11	10	8	18	3	2	3	0
	2	Сэтгэц болон зан үйлийн эмгэг	17	9	23	32	5	0	3	1
	3	Дотрын өвчин	59	94	23	117	21	3	19	3
	4	Мэдрэлийн өвчин	15	50	2	52	23	0	2	0
	5	Нүдний өвчин	5	4	3	7	1	0	5	0
	6	Чих,хамар,хоолойн өвчин	18	2	17	19	6	1	8	0
	7	Мэс заслын өвчин	31	20	25	45	8	0	13	2
	8	Эх барих, эмэгтэйчүүдийн өвчин	6	0	6	6	0	0	2	0
	9	Арьсны өвчин	7	9	4	13	4	1	10	0
	10	Гэмтэл, согогийн өвчин	56	27	43	70	17	13	25	0
	12	Хэсгийн дүн	225	225	154	379	88	20	90	6
		Үйлдвэрлэлийн осол	12	4	10	14	4	14	0	0

Харин шинэчилсэн өвчний жагсаалтад дараах саналыг тусгав. Үүнд:

- 1.Хугацаагүйгээр тогтоох 9 заалт нэмэгдүүлсэн;
- 2.Шинээр 20 заалт нэмэгдсэн;
- 3.Өөрчлөлт оруулсан 90 заалт;
- 4.Хасагдсан 6 заалт нийт зэрэг болно.Тухайлбал:

Хугацаагүй заалт

- 1.8 б/Амьсгалын болон бусад эрхтний маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (МОЭТС) бүх тохиолдол Сэдрэлийн ба намжмал үе
- 3.45 Өнчин тархины ба бусад шалтгаантай өсөлтийн дааврын дутагдал а/Биеийн өндөр 131-140 см бол
- 10.34 Биеийн гадаргууны 18 хувиас бага талбайтай 3, 4 дүгээр зэргийн түлэгдлийн улмаас гар, хөл, хүзүү, толгойн хөдөлгөөнийг эрс хязгаарласан нөхөн сэргээх мэс засал эмчилгээнд засагдаагүй бол сорви бол
- 7.30 Хоргүй хавдар, хавдар төст өвчний улмаас орчны эд эрхтэнийг дарсан, үйл ажиллагааг алдагдуулсан ч өвчтөний биеийн байдал, нас, хавсарсан өвчин, хавдрын байдал зэрэг шалтгаанаас мэс засал хийх боломжгүй тохиолдлууд, тэдгээрийн хүндрэл
- 3.54 Цус бүлэгнэлтийн эмгэг /Виллебрандын өвчин, гемофили А ба В/ гэх мэт...

Шинээр нэмэгдсэн заалт

- 1.3 Сорвит хөндийт сүрьеетэй, сэдрэлийн үе, архаг хордлого, хоёр уушги хамарсан зүрх судасны дутагдлын II, III үе
- 1.6 Сүрьеэгийн улмаас эрхтэн тогтолцооны талаас дахин сэргэхгүй өөрчлөлтөнд орсон (амьсгал, зүрх судасны архаг дутагдалтай, яс үе мөчний сүрьеэ, менингит)
- 3.24 "Архаг тофустай, өвчний идэвхжилийн өндөр зэрэгтэй, хүндрэлтэй тулай." а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III "б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV, бусад эрхтэн тогтолцоонд хүндрэлтэй"
- 3.30 Уушигны артерийн бүлэнт бөглөрөл
- 10.29 Түлэгдэлтийн улмаас биеийн 1-2 үе болон хүзүү их биеийн хөдөлгөөн хязгаарласан сорвижилтын үед
- 10.30 Түлэгдэлтийн улмаас тэжээлийн дутагдлын шарх үүссэн (2 сараас дээш хугацаанд эдгээгүй архаг шархлаа) гэх мэт ...

Өөрчилөлт оруулсан заалт

3 дугаар бүлгийн 3.32а заалт “Хепатитийн В, Делта вирусийн шалтгаант архаг үрэвслийн үед Пег-интерферон эмчилгээ хийх хугацаанд” гэснийг Хепатитийн В, Делта вирусийн шалтгаант архаг үрэвслийн үед **Д вирусийн эсрэг өвөрмөц эмчилгээ (пег-интерферон, булевертид, лонафарниб)** эмчилгээ хийх хугацаанд” гэх мэт... 90 заалтад өөрчлөлт оруулав.

Хасагдсан заалт

- 1.1-2-11-2 Стресстэй холбоотой неврозын болон биеийн хэлбэрийн эмгэгүүд Айдаст сэтгэл түгших, үл ялиг зовлонт үзэгдлийн, дасан зохицохуйн, диссоциатив, биеийн хэлбэрийн, мэдрэл сульдах эмгэгүүд- 41
2. 1-3-37 Чихрийн шижин хэвшинж II, хүнд зэргийн ээнэгшил алдагдалтай-37
3. 1-3-40-1 а/Бамбайн хордлогын дунд зэрэг, ээнэгшлийн бус үе-9
4. 1-3-47 Таргалалт өвчний хүнд хэлбэр (Цусны эргэлтийн дутагдал, пиквикийн хам шинж зэрэг эрхтэн тогтолцооны дутагдал илэрсэн III зэргийн таргалалт)-16
5. 1-7-29 Хавдрыг эмчилсний дараа дахилт, үсэрхийлэл өгөөгүй-112

6. 1-7-31 Хавдартай эрхтэн авч эрхтэн шилжүүлэн суулгасан хагалгааны дараах үе-17 зэрэг болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны www.mlsp.gov.mn цахим хаягт хамтарсан тушаалын төслийг 2023 оны 08 сарын 29-ний өдрөөс байршуулж ажил олгогч, даатгуулагч, хүн, төрийн бус байгууллагаас санал авч байна.

Хамтарсан тушаал батлагдсанаар эрүүл мэндийн магадлалын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, даатгуулагч хүнд эмнэлэг хяналтын комисс, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх, хяналтыг сайжруулах, үйл ажиллагааг цахимжуулах, ил тод болгох зэрэг олон эерэг өөрчлөлт гарна.

Энэхүү хамтарсан тушаалыг хэрэгжүүлэхэд зардал, орон тоо шинээр нэмэгдэхгүй ба одоо ашиглаж байгаа хүний нөөц, техник хэрэгсэл, батлагдсан бичиг хэргийн болон бусад зардлын хүрээнд хэрэгжүүлэн ажиллах боломжтой.

---oOo---